

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ӨРХ, ХУНАМЫН СУДАЛГАА-2019

ТАНИЛЦУУЛГЫН АГУУЛГА

ОРШИЛ

- Танилцуулгын зорилт
- Танилцуулгын аргачлал

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

- Хүн амын тооны өсөлт, нас, хүйсийн бүтэц

ХОЁРДУГААР БҮЛЭГ

- Хүн амын насжилт, хүйсийн харьцаа

ГУРАВДУГААР БҮЛЭГ

- Хүн ам зүйн ачаалал

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

- Өрхийн тоо, байршил

ХАВСРАЛТ

- Дүгнэлт
- Мэдээллийн эх үүсвэр
- Нэр томъёоны тайлбар

ОРШИЛ

Хүн амын өсөлт, нас хүйсийн бүтэц, түүний өөрчлөлт нь нийгэм, эдийн засагт шууд болон шууд бусаар нөлөөлж байдаг бөгөөд хүн амд чиглэсэн ямар бодлого, хөтөлбөр боловсруулах вэ гэдгийг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Иймд хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтэд статистикийн арга аргачлалыг ашиглан судалгаа дүгнэлт хийж, төлөв байдлыг тодорхойлох нь зүй ёсны шаардлага болно.

Хүн ам зүй нь нийгмийн гол үзүүлэлтийн өгөгдөл бөгөөд аливаа тоон судалгаа болон хэтийн төсөөлөл нь хүн амын судалгаан дээр суурилдаг учраас чухал судалгаа мөн юм.

Танилцуулгын зорилго:

Энэхүү танилцуулгадаа Сэлэнгэ аймгийн 2019 оны хүн амын тоо, түүний өөрчлөлт, нас хүйс, хүн амын шилжилт хөдөлгөөн, төрөлт, өрх мөн хүн амын дундаж наслалт, өсөлт гэх мэт хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэн гаргаж, дүгнэлт гаргахыг зорилоо.

Танилцуулгын аргачлал:

Танилцуулагыг бэлтгэхийн тулд 2019 оны суурин хүн амын жилийн эцсийн тайлан, хүн ам ердийн хөдөлгөөний тайлан, хүн амын шилжилт хөдөлгөөний тайлан мэдээний үзүүлэлтийг ашиглан үзүүлэлтүүдийг тооцлоо.

I. ХҮН АМЫН ТОО, НАС ХҮЙСИЙН БҮТЭЦ

Сэлэнгэ аймгийн суурин хүн амын тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 107 755 байна. Хүн амын 50.8 хувь буюу 54 706 нь эрэгтэйчүүд, 49.2 хувь буюу 53 049 нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ-1 СЭЛЭНГЭ АЙМГИЙН СУУРИН ХҮН АМЫН ТОО,
СУМААР, ХҮЙСЭЭР, 2019 ОН


Сумын нэр	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Алтанбулаг сум	4 750	2 411	2 339
Баруунбүрэн сум	3 094	1 609	1 485
Баянгол сум	5 567	2 884	2 683
Ерөө сум	6 834	3 520	3 314
Жавхлант сум	1 970	1 076	894
Зүүнбүрэн сум	2 819	1 380	1 439
Мандал сум	27 011	13 755	13 256
Орхон сум	2 290	1 218	1 072
Орхонтуул сум	3 754	2 000	1 754
Сайхан сум	9 302	4 711	4 591
Сант сум	2 104	1 093	1 011
Сүхбаатар сум	22 578	11 061	11 517
Түшиг сум	1 835	937	898
Хүдэр сум	2 706	1 410	1 296
Хушаат сум	2 067	1 088	979
Цагааннуур сум	5 081	2 558	2 523
Шаамар сум	3 993	1 995	1 998
Нийт	107 755	54 706	53 049

ХҮСНЭГТ- 2 ХҮН АМЫН ТОО, ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДААР, 2019 он

	2019
Улсын дүн	3 197 020
Төвийн бүс	506 195
Төв	92 409
Говьсүмбэр	17 445
Сэлэнгэ	107 755
Дорноговь	69 859
Дархан-Уул	102 171
Өмнөговь	69 858
Дундговь	46 698



ГРАФИК- 2 ХҮН АМЫН ТОО, ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДААР, эзлэх хувиар, 2019 он



Төвийн бүс нь Улсын дүнгийн 15.8 хувь Сэлэнгэ аймаг нь хүн амын тоогоороо төвийн бүсдээ нэгдүгээрт ордог ба төвийн бүсийн аймгуудийн нийт хүн амын 107 755 буюу 21.3 %-ийг эзэлдэг байна.

ХҮН АМЫН ӨСӨЛТ


Хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгэм, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамаардаг. Сэлэнгэ аймгийн хүн амын дундаж өсөлт сүүлийн 10 жилийн байдлаар 1.8% байна.

ХҮСНЭГТ-3 СЭЛЭНГЭ АЙМГИЙН СУУРИН ХҮН АМЫН ТОО СҮҮЛИЙН 10 ЖИЛИЙН БАЙДЛААР

Он	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Суурин хүн ам	103 698	104 282	105 234	105 253	104 725	106 677	108 768	109 255	107 755
Өсөлтийн хувь	1.9	0.6	0.9	0.0	-0.5	1.9	2.0	0.4	-1.4

ГРАФИК-3

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СУУРИН ХҮН АМЫН ӨСӨЛТ СҮҮЛИЙН 10 ЖИЛИЙН




ХҮСНЭГТ-4 ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, 1000 хүнд ноогдохоор, сүүлийн 10 жилийн байдлаар

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Төрөлт	24.3	25.5	23	18.7	19.7	18.6	25.4	15.8	15.4	15.8
Нас баралт	7.2	6.7	4.5	6.4	4.7	6.4	5.2	4.5	4.8	4.5
Цэвэр өсөлт	17.1	18.8	18.5	12.4	15	12.3	20.2	11.3	10.6	11.3

ГРАФИК-4

ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЦЭВЭР ӨСӨЛТ 1000 ХҮНД НООГДОХООР, 2009 - 2018 ОНУУДААР




Төрөлтийн ерөнхий коэффициент 2011 оноос хойш буурч, 2014 онд 19.7 болж суурьшин, 2016 онд 25.4 болж өсч байгаад 2017- 2019 онд 15.4-15.8 болж 2016 оноос 9.6-10 пунктээр буурсан байна. Нас баралтын коэффициент харьцангуй тогтмол бөгөөд 2019 онд 4.5 болж өмнөх оноос 0.3 пунктээр буурсан байна. Ердийн цэвэр өсөлт 2019 онд өмнөх оноос 0.7 пунктээр өсч 11.3 болсон байна.

ХҮСНЭГТ-5 СУУРИН ХҮН АМЫН ӨСӨЛТ, сумаар , хувиар

Сумын нэр	2018	2019	Өсөлтийн хувь
Нийт	109 255	107 755	-1.4
Сүхбаатар	23 151	22 578	-2.5
Алтанбулаг	5 008	4 750	-5.2
Баруунбүрэн	3 162	3 094	-2.2
Баянгол	5 579	5 567	-0.2
Ерөө	6 856	6 834	-0.3
Жавхлант	1 962	1 970	0.4
Зүүнбүрэн	2 865	2 819	-1.6
Мандал	27 241	27 011	-0.8
Орхон	2 377	2 290	-3.7
Орхонтуул	3 788	3 754	-0.9
Сайхан	9 418	9 302	-1.2
Сант	2 143	2 104	-1.8
Түшиг	1 848	1 835	-0.7
Хүдэр	2 651	2 706	2.1
Хушаат	2 065	2 067	0.1
Цагааннуур	5 077	5 081	0.1
Шаамар	4 064	3 993	-1.7

ГРАФИК-5 СЭЛЭНГЭ АЙМГИЙН СУУРИН ХҮН АМЫН ӨСӨЛТ, сумаар, хувиар, 2019 он



ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ


Хүн амын нас, хүйсийн бүтцийг судлах нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм.

Хүн амын төрөлт, нас баралтын түвшингээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан, хөгшчүүд байдгаас хамааран үе үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг. Тухайлбал үйлдвэр, уурхай, барилга, хөдөө аж ахуйн зэрэг салбарт ажиллах хүн хүчний нөөц хэр зэрэг байх, сургууль, эмнэлэг, үйлчилгээний байгууллагын хүчин чадал байршил ямар байх зэрэг нь хүн амын насны бүтцээс хамаарч зохицуулагддаг билээ.

ХҮСНЭГТ-6 ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ 2019 ОНЫ БАЙДЛААР

Насны бүлэг	0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
Сэлэнгэ аймаг	11 889	11 529	9 366	7 915	7 994	8 252	8 570	7 683	7 304	7 024	6 298	5 507	3 715	2 108	2 601

ГРАФИК-6 СЭЛЭНГЭ АЙМГИЙН СУУРИН ХҮН АМ, насны бүтцээр, 2019 он




Сэлэнгэ аймгийн хүн амын хамгийн их 31.0%-ийг 0-14 насныхан буюу хүүхдүүд эзэлж байгаа бол хамгийн бага 12.0%-ийг ахмадууд буюу 55-с дээш насных эзэлж байна. Улс орон нутгийн хөгжлийн гол тулгуур болсон 25-34 насны залуучууд аймгийн нийт хүн амын 16.0% - ийг эзэлж байна.

ХҮСНЭГТ-7 ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ сүүлийн 3 жилийн байдлаар

Насны бүлэг	2017	2018	2019
0-4	11 926	12 242	11 889
5-9	11 422	11 508	11 529
10-14	8 309	8 769	9 366
15-19	8 625	8 341	7 915
20-24	8 415	8 312	7 994
25-29	9 874	9 229	8 252
30-34	8 603	8 732	8 570
35-39	7 940	7 793	7 683
40-44	7 591	7 506	7 304
45-49	7 009	6 963	7 024
50-54	6 397	6 477	6 298
55-59	5 092	5 350	5 507
60-64	3 223	3 533	3 715
65-69	1 852	1 949	2 108
70+	2 490	2 551	2 601

ГРАФИК-7 СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТ, насны бүтцээр, сүүлийн 3 жилийн байдлаар




Дээрх графикаас харахад 2019 онд хүн амын тоо 10-14 насанд 12.3 хувиар 60-64 насанд 5.2 хувиар хамгийн их өссөн үзүүлэлтэй байна. Харин 25-29 насныхан 10.6 хувиар, 15-19 насныхан 5.1 хувиар хамгийн их буурсан байна. Бусад насныханы хувьд харьцангуй тогтмол үзүүлэлтэй байна.

ХҮСНЭГТ-8 ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ сүүлийн 5 жилийн байдлаар

Он	Бүгд	0-15 насны хүүхэд	%	Хөдөлмөрийн насны	%	Тэтгэврийн насны	%
2015	104 273	32 368	30.4%	67 983	64.0%	5 941	5.6%
2016	106 677	30 846	28.9%	71 797	67.3%	4 034	3.8%
2017	108 768	31 657	29.0%	72 769	67.0%	4 342	4.0%
2018	109 255	32 519	29.8%	72 226	66.1%	4 510	4.1%
2019	107 755	32 784	30.4%	70 262	65.2%	4 709	4.4%

ГРАФИК-8 СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТ, насны бүтцээр , сүүлийн 5 жилийн байдлаар




Нийт суурин хүн амын 30.4 хувийг 0-15 насны хүүхэд, 65.2 хувийг хөдөлмөрийн насны хүн ам, 4.4 хувийг тэтгэвэрийн насны хүн ам эзэлж байна. Нийт хүн амд 0-15 насны хүүхдийн эзлэх хувь 2019 онд өмнөх оноос 0.6 пунктээр, тэтгэвэрийн насны хүн ам 0.3 пунктээр өсч, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь өмнөх оноос 0.9 пунктээр буурсан байна.

II. ХҮН АМЫН НАСЖИЛТ, ХҮЙСИЙН ХАРЬЦАА

ХҮСНЭГТ- 9 СУУРИН ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, хүйсээр, сүүлийн 10 жилийн байдлаар

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт	68.93	70.09	70.85	71.27	71.87	72.42	72.11	72.08	72.13	72.25
Эрэгтэй	65.21	65.9	66.67	67.06	67.61	68.08	67.9	67.81	67.67	67.96
Эмэгтэй	74.48	75.23	75.98	76.43	77.1	77.79	78.27	78.33	78.49	78.42

ГРАФИК-9 ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, хүйсээр, сүүлийн 10 жилийн байдлаар




2019 онд Сэлэнгэ аймгийн хүн амын дундаж наслалт 72.25 байгаа нь урьд оноос 0.12-оор өссөн үзүүлэлтэй байна. Хүйсээр нь ялгаж үзвэл эмэгтэйчүүдийн дундаж наслалт 78.42 байгаа бол эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдээс 10.46 насаар бага буюу 67.96 байна. Эндээс эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү урт насалдаг болохыг харж болно.

ХҮСНЭГТ-10 ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС,
ХҮЙСИЙН ХАРЬЦААГААР 2019 ОН

Насны бүлэг	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
0-4	6 066	5 823	104.2
5-9	5 929	5 600	105.9
10-14	4 757	4 609	103.2
15-19	4 024	3 891	103.4
20-24	4 189	3 805	110.1
25-29	4 489	3 763	119.3
30-34	4 585	3 985	115.1
35-39	4 032	3 651	110.4
40-44	3 828	3 476	110.1
45-49	3 520	3 504	100.5
50-54	2 981	3 317	89.9
55-59	2 637	2 870	91.9
60-64	1 686	2 029	83.1
65-69	960	1 148	83.6
70+	1 023	1 578	64.8

ГРАФИК-10 ХҮН АМЫН СУВАРГА




Хүн амын тоо хэмжээний өсөлтийг жилээр харьцуулж харах, түүнчлэн нас, хүйсийн бүтэц нэг хэвийн биш байгаа эсэхийг хараад шууд мэдэхэд ойлгомжтой, тохиромжтой байх үүднээс суваргыг бодит тоогоор (хувийн жингээр биш) зурсан. Хүн амын нас хүйсийн суваргаас харахад дунд хэсгээрээ өргөсч байгаа нь хүн ам идэршиж байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ-11 СУУРИН ХҮН АМЫН ТОО, хүйс, хүйсийн харьцаагаар, сүүлийн 10 жилийн байдлаар

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Эрэгтэй	50 569	51 816	52 082	52 700	53 019	53 165	53 942	55 067	55 353	54 706
Эмэгтэй	51 183	51 882	51 200	52 534	52 234	51 560	52 735	53 107	53 902	53 049
Хүйсийн харьцаа	98.8	99.9	101.7	100.3	101.5	103.1	102.3	102.5	102.7	103.1

ГРАФИК-11 ХҮЙСИЙН ХАРЬЦАА, сүүлийн 10 жилийн байдлаар



100 эмэгтэй тутамд ногдож буй эрэгтэйчүүдийн тоогоор илэрхийлэгддэг хүйсийн харьцаа нь сүүлийн жилүүдэд аажим өсч байгаад 2016 онд 0.8 хувиар буурч байгаад сүүлийн 3 жилд 0.2-0.4 хувиар өсч байгаа нь эрэгтэйчүүдийн хувийн жин аажмаар өсч байгааг харуулж байна. Энэ онд 100 эмэгтэй тутамд 103 эрэгтэй оногдож байна. Энэ нь хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй байгааг харуулж байна.

III. ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ


ХҮН АМЫН СУУРЬШИЛ, НЯГТРАЛ

Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйн зэрэгцээ газарзүйн янз бүрийн бүсэд оршдог, байгалийн баялаг улс орны нутаг дэвсгэрт жигд бус тархсан, уур амьсгал газарзүйн бүсүүдэд ялгаатай, эрс тэс байдаг зэргээс хамааран аймаг, нийслэлийн хүн амын суурьшил, нягтрал, хөгжлийн төвшин өөр өөр байгаа нь зүй ёсны асуудал билээ. Хүн амын суурьшлыг хот, хөдөө, бүс нутгаар тодорхойлох нь тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг гүнзгийрүүлэн судалж, бүс нутгийн болон орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулах үндэс болно.

ХҮСНЭГТ-12 ХҮН АМЫН ТОО, БАЙРШЛААР, сүүлийн 5 жилийн байдлаар

Хүн амын тоо		2015	2016	2017	2018	2019
		104 725	106 677	108 768	109 255	107 755
Үүнээс	Аймгийн төв	22 238	22 482	22 741	23 151	22 578
	Хот, тосгонд	33 540	35 374	13 717	14 777	14 639
	Сумын төв	40 703	34 201	52 203	55 715	52 130
	Хөдөөд	8 285	14 620	20 197	15 612	18 408

ГРАФИК-12 ХҮН АМЫН БАЙРШИЛ, хувиар, 2019 он



Нийт хүн амын 21.0 хувь нь аймгийн төвд, 13.6 хувь нь хот тосгонд, 48.4 хувь нь сумын төвд, 17.1 хувь нь хөдөө амьдарч байна.

ХҮН АМЫН НЯГТРАЛ

Улс төр, соёл, түүх, засаг захиргаа, цаг агаар, газарзүй зэрэг олон хүчин зүйлс хүн амын суурьшил, улмаар хүн амын нягтралд нөлөөлдөг. Бүс нутаг, аймаг, нийслэлийн хүн амын нягтралд хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйлс нь шилжих хөдөлгөөн юм.

Сэлэнгэ аймгийн нэг хавтгай дөрвөлжин квадрат километр нутаг дэвсгэрт 2018 онд 2.6 хүн ноогдож байгаа нь улсын хэмжээнд нягтрал ихтэй аймгийн тоонд орж байна.

ХҮСНЭГТ-13 СУУРИН ХҮН АМЫН ТОО, НЯГТРАЛ, СУМААР, ХУВИАР, 2018 ОН

Сумын нэр	Нийт хүн амын тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээ	Хүн амын нягтшил
Нийт	107 755	41 152,6	2.6
Алтанбулаг	4 750	2 100.3	2.3
Баруунбүрэн	3 094	2 814.5	1.1
Баянгол	5 567	1 976.3	2.8
Ерөө	6 834	8 203.5	0.8
Жавхлант	1 970	1 189.7	1.7
Зүүнбүрэн	2 819	1 204.9	2.3
Мандал	27 011	4 843.7	5.6
Орхон	2 290	1 306.3	1.8
Орхонтуул	3 754	2 940.8	1.3
Сайхан	9 302	1 311.9	7.1
Сант	2 104	1 387.0	1.5
Сүхбаатар	22 578	45.4	497.3
Түшиг	1 835	2 492.8	0.7
Хүдэр	2 706	2 010.2	1.3
Хушаат	2 067	2 838.7	0.7
Цагааннуур	5 081	3 814.7	1.3
Шаамар	3 993	671.9	5.9

Дээрх хүснэгтээс харахад хүн амын хамгийн их нягтралтай нь Сүхбаатар сум 1км² талбайд 497.3 хүн ногдож байна. Сүхбаатар сумын дараагаар 1км² талбайд 5-7 хүн ногдож байгаа Мандал, Шаамар, Сайхан сумдууд орж байна. Харин Түшиг, Хүдэр, Ерөө сумдад хүн амын нягтрал хамгийн сийрэг, 1км² талбайд 0.7-0.9 хүн ногдож байна.


IV. ӨРХИЙН ТОО, БАЙРШИЛ

Сэлэнгэ аймгийн өрхийн тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 29 004 буюу өмнөх оноос 3.7 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Энэ нь 1 өрхөд дундажаар 3.61 хүн ам ногдож байгааг илэрхийлж байна.

ХҮСНЭГТ-14 ӨРХИЙН ТОО, НЭГ ӨРХӨД НООГДОХ ХҮН АМЫН ТОО, сүүлийн 6 жилийн байдлаар

Он	Нийт өрхийн тоо	Нийт хүн ам	Нэг өрхөд ногдох хүн амын тоо
2014	30 040	105 253	3.5
2015	29 316	104 725	3.57
2016	29 521	106 677	3.61
2017	29 912	108 768	3.64
2018	30 123	109 255	3.63
2019	29 004	107755	3.71


ГРАФИК-14 ӨРХИЙН ТОО, сүүлийн 6 жилийн байдлаар



ХҮСНЭГТ-11 ӨРХИЙН ТОО,сумаар,сүүлийн 5 жилийн байдлаар

Сумын нэр	2015	2016	2017	2018	2019
Дүн	29 316	29 521	29 912	30 123	29 004
Алтанбулаг	1 330	1 332	1 369	1 368	1 251
Баруунбүрэн	891	909	920	894	834
Баянгол	1 615	1 616	1 623	1 636	1 608
Ерөө	1 820	1 816	1 875	1 922	1 863
Жавхлант	648	700	712	636	567
Зүүнбүрэн	797	797	865	838	795
Мандал	7 215	7 199	7 238	7 298	6 944
Орхон	734	753	848	754	686
Орхонтуул	1 008	1 009	1 032	1 080	1 048
Сайхан	2 630	2 653	2 656	2 732	2 705
Сант	630	751	644	728	645
Сүхбаатар	5 845	5 811	5 870	5 903	5 831
Түшиг	530	538	547	552	539
Хушаат	536	556	573	596	558
Хүдэр	633	647	653	658	669
Цагааннуур	1 297	1 319	1 368	1 379	1 336
Шаамар	1 157	1 115	1 119	1 149	1 125

ГРАФИК-12 ӨРХИЙН ТОО, сумаар, эзлэх хувиар, 2019 он



ХАВСРАЛТ

ДҮГНЭЛТ

Сэлэнгэ аймгийн хувьд хүн ам олонтой аймгуудын тоонд ордог, мөн түүнийгээ даган шилжилт хөдөлгөөн ихтэй, томоохон аймгуудын нэг билээ. 2019 оны жилийн эцсийн байдлаар манай аймгийн суурин хүн ам 107 755-д хүрч 2015 оноос 2.9 хувиар, 2016 оноос 1.0 хувиар өссөн бол, 2017 оноос 0.9 хувиар, 2018 оноос 1.4 хувиар буурсан байна. 100 эмэгтэй тутамд ногдох эрэгтэйчүүдийн тоо сүүлийн жилд аажмаар өсч байгаа нь нийт хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өсч, хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй болж байгааг харуулж байна. Хүн амын нас, хүйсийн суваргаас харахад бүтэц хэвийн харагдаж байна. Манай аймгийн нэг хавтгай дөрвөлжин квадрат километр нутаг дэвсгэрт 2019 онд 2.6 хүн ноогдож байгаа нь улсын хэмжээнд нягтрал ихтэй аймгийн тоонд орж байна.

1000 хүнд ногдох төрөлтийн дүнгээс харахад Төрөлтийн ерөнхий коэффициент 2011 оноос хойш буурч, 2014 онд 19.7 болж суурьшин, 2016 онд 25.4 болж өсч байгаад 2017- 2019 онд 15.4-15.8 болж 2016 оноос 9.6-10 пунктээр буурсан байна. Нас баралтын коэффициент харьцангуй тогтмол бөгөөд 2019 онд 4.5 болж өмнөх оноос 0.3 пунктээр буурсан байна. Ердийн цэвэр өсөлт 2019 онд өмнөх оноос 0.7 пунктээр өсч 11.3 болсон байна. 2019 онд Сэлэнгэ аймгийн хүн амын дундаж наслалт 72.25 байгаа нь урьд оноос 0.12-оор өссөн үзүүлэлтэй байна.

Сэлэнгэ аймгийн өрхийн тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 29 004 буюу өмнөх оноос 3.7 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Танилцуулгыг бэлтгэсэн: Мэргэжилтэн.....Б.Хулан

Хянасан: Хэлтсийн дарга.....Д.Гүндэгмаа

МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

- Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн 12 сарын танилцуулга 2010-2019 он
- Хүн амын үзүүлэлтийг тооцох аргачлал, түүнийг ашиглах гарын авлага 2015 он
- Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын үр дүн
- www.selenge.nso.mn
- www.1212.mn
- www.nso.mn

Нэр томъёоны тайлбар:

- **Хүн амын бүртгэл.** Тухайн газар нутагт тодорхой цаг хугацааны дотор гарсан хүн ам зүйн үзэгдэл болон хүн амыг бүртгэж авах үйл явц болно.
- **Хүн амын тоо.** Тодорхой хугацаанд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын тоог бэлэн болон суурин хүн амаар тооцдог.
- **Суурин хүн ам.** Тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа бүх хүнийг суурин хүн ам гэнэ. Мөн 6 сараас доош хугацаагаар түр эзгүй байгаа байнга оршин суудаг хүмүүсийг суурин хүн амын бүртгэлд оруулна.
- **Өрх.** Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэж үзнэ.
- **Хүйсийн харьцаа.** Хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлт нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлдэг.
- **Хүн ам зүйн ачаалал.** Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоог харуулдаг.
- **Хүн амын нас-хүйсийн суварга.** Судалгаанд хүн амын нас, хүйсийн суваргаар нас, хүйсийн бүтцийг зураглан харуулдаг. Энэ нь зэрэгцүүлэхэд хялбар, хүйсний ялгавраар төв абцисс тэнхлэгээс хамгийн залуугаас эхлэн насны өсөх дарааллаар, доороос дээш суварган хэлбэртэй байна. Нас, хүйсний бүлэг бүр 100 хувьтай тэнцүү байна.
- **Төрөлтийн ерөнхий коэффициент.** Энэ үзүүлэлт нь тухайн жилд 1000 хүн амд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулдаг.
- **Нас баралтын ерөнхий коэффициент.** Нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцаа бөгөөд энэ үзүүлэлт нь 1000 хүн амд ногдох нас баралтын тоог илэрхийлдэг.

